



**ШИНЭ ИХ ТЭРБУМ
АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
1-р хороо, 12-р хороолол, North center, 204 тоот
Утас: 9919-9075, 8804-3708, И-мэйл: Ikhterbum@gmail.com

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ТАНАА

2023.01.16 № 23/02
танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Тандэм инвест ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нэмэлт тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр компанийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)-ын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайланд аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан.

Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЭЗОУСЗ”)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайланд ББСБ-ын удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах болон алдаа эсвэл залилангаас үүдэлтэй материаллаг алдаатай илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)
“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчид танаа

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлдэг гэсэн баталгаа гаргадаггүй.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Д.Данцдулам -Туйцэтгэх захирал, МНБ

"ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ" ХК

АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ХУРААНГУЙ
2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)

БАЛАНС

	12/31/2022	12/31/2021
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	621,309,138	449,569,419
Зээл (цэвэр)	16,649,740,632	6,326,741,104
Бусад авлага	259,179,859	79,001,295
Бусад хөрөнгө	3,399,730	90,908,432
Үндсэн хөрөнгө (цэвэр)	486,454,309	43,659,304
Биет бус хөрөнгө (цэвэр)	1,930,521	2,661,771
Нийт хөрөнгийн дүн	18,022,014,189	6,992,541,325
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	3,464,131,004	1,008,801,600
Бусад өр төлбөр	301,447,000	111,835,786
Хувьцаат капитал	3,465,098,908	2,597,931,801
Нэмж төлөгдсөн капитал	8,779,112,743	2,294,210,877
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	2,012,224,534	979,761,261
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	18,022,014,189	6,992,541,325

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Хүүгийн орлого	3,051,928,920	1,138,252,209
Хүүгийн бус орлого	181,935,423	39,070,261
Хүүгийн бус зардал	(899,768,500)	(378,348,339)
Зээлийн эрсдэлийн зардал	(51,154,298)	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг	2,282,941,545	798,974,131
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	267,300	205,677,853
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(62,268,328)	(22,464,888)
Татвар төлөхийн өмнөх ашиг	2,220,940,517	982,187,096
Орлогын албан татвар	(227,324,564)	(10,053,419)
Цэвэр ашиг (алдагдал)	1,993,615,953	972,133,677

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хувьцаат капитал	3,468,668,428	2,601,501,321
Халаасны хувьцаа	(3,569,520)	(3,569,520)
Нэмж төлөгдсөн капитал	8,779,112,743	2,294,210,877
Хуримтлагдсан ашиг	2,012,224,534	979,761,261
Нийт эздийн өмчийн дүн	14,256,436,185	5,871,903,939

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	14,840,857,279	6,061,957,665
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	(21,606,234,998)	(8,568,031,581)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(6,765,377,719)	(2,506,073,916)
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	7,456,432,929	2,580,419,559
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	(519,315,491)	(69,091,026)
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	6,937,117,438	2,511,328,533
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	171,739,719	5,254,617
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	449,569,419	444,314,802
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	621,309,138	449,569,419

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.